

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН “САНХҮҮГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2026 ОН

АГУУЛГА

НЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ. 3

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ 3

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ
4

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ 5

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ 10

НЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг батлах тухай хуулийн төсөл нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-г заавал Монгол Улсын Их Хурал соёрхон батлахаар заасны дагуу хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар боловсруулсан.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох,
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох,
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох,
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн болно. Үүнд:

1. Зорилтод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
5. Зардал
6. Харилцан уялдаа зэрэг болно.

/Хүснэгт 1/

<p>“Зорилтод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:</p>	<p>Хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх (бүрэн илэрхийлж чадсан эсэх), хуулийн төсөлд туссан зохицуулалт болон арга хэмжээнүүд нь хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэлсэн болно.</p> <p>Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилтод хүрэхэд чиглэгдсэн мөн түүний тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан.</p>
---	---

“Практикт боломж” хэрэгжих шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тооцож үзсэн.
“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарал бүхий этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонгосон.
“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгагдаагүй боловч хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, төрийн байгууллагаас санал авах, зэргээр хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг судлахаар тус аргачлалыг сонгосон болно.
“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төсөл батлагдсанаар хэрэгжих төслийн хүрээнд нэмэлт зардал үүсэх эсэх, төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.
“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төслийг Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээ хийхээр тооцсон.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Зорилтод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон хууль зүйн болон практик үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтууд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэгдсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тусгайлан гаргах тул энэхүү үр нөлөөний үнэлгээнд оруулаагүй болно.

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй учир үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоохдоо сонгосон 5 шалгуур үзүүлэлт тус бүрээр үр нөлөөг тогтоох судалгаа хийсэн.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг доорх байдлаар үзүүлэв.

/Хүснэгт 2/

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилтод хүрэх байдал	<p>1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.</p>	<p>Зорилтод дүн шинжилгээ хийх:</p> <p>Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн үзэл баримтлалд туссан “Хорт хавдрын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл”, “Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл”, “Монгол Улсад эх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах төсөл”, “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, “Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн гуравдугаар шатны төсөл”, “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ба хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах дараагийн шатны төсөл”, “Дуурь бүжгийн эрдмийн</p>

			театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл төсөл"-үүдийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
2	Практикт хэрэгжих боломж		<p>Практикт турших:</p> <p>Хуулийн төсөл нь Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газартай байгуулсан "Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл бөгөөд хоёр улсын Засгийн газар хооронд 2011, 2016, 2019 онуудад тус бүр 40.0 сая еврогийн нийт 120.0 сая еврогийн оноос эхлэн "Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-үүдийг Улсын Их Хурлаар соёрхон баталж тус "Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-үүдийн хүрээнд зээлийн эх үүсвэрээр амжилттай төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.</p>
3	Ойлгомжтой байдал		<p>Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах зорилгоор хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дээрх заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд</p>

			хариулт өгөх замаар шалгасан. /Хүснэгт 3/
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал		Хуулийн төсөл нь Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газартай байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл бөгөөд хоёр улсын Засгийн газар хооронд 2011, 2016, 2019 онуудад тус бүр 40.0 сая еврогийн нийт 120.0 сая еврогийн оноос эхлэн “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-үүдийг Улсын Их Хурлаар соёрхон баталж тус “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-үүдийн хүрээнд зээлийн эх үүсвэрээр амжилттай төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа бөгөөд хуулийн төслийг хэрэгжүүлэгч байгууллагууд болох Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газрын зүгээс хуулийн төсөл батлагдсанаар “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг хүчин төгөлдөр гэж авч үзнэ.
5	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Хуулийн төсөл батлагдсанаар гарах зардлын тооцооллыг аргачлалын дагуу тусдаа гүйцэтгэсэн болно.
6	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын тайланд дурдсан. /Хүснэгт 4/

2. Ойлгомжтой байдлыг шалгах

Хуулийн төслийн зохицуулалт нь найруулга, хэлзүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих

нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд дор дурдсанаар нарийвчлан үнэлж байна:

/Хүснэгт 3/

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлага хангасан.
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл,	Шаардлага хангасан.

хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Шаардлага хангасан.
29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлага хангасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Шаардлага хангасан.

3. Хуулийн төслийн харилцан уялдаа холбоог шалгах

Дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоож байна:

/Хүснэгт 4/

Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм
Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцсэн.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөл нэг зүйлтэй.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Тийм
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, судалгааг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулан хавсаргав. Үүнд:

1. Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан,
2. Хуулийн төслийн үзэл баримтлал, түүнд нийцүүлэн боловсруулсан хуулийн төслийн хувилбар,
3. Хуулийн төсөлтэй холбоотой төрийн байгууллагуудын санал.

Дүгнэлт

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д заасны дагуу тооцож, сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтэн дараах дүгнэлтэд гаргав. Үүнд:

- Энэхүү үнэлгээг сонгосон шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон бусад хууль тогтоомж болон хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй байна.
- Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийхэд хуулийн төслийг ойлгомжтой болгох чиглэлээр санал ирүүлээгүй байна.
- Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.
- Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгаж, уялдаа холбоог хангасан гэж үзсэн.